

БАТЛАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
ИННОВАЦ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР



ЦОЛМОНБААТАР

ГАРААНЫ КОМПАНИЙН ТӨСӨЛ БОЙЖУУЛАХ "MUST START-UP 3.0" ХӨТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

Хөтөлбөрийн зорилго: Гарааны компани байгуулах сонирхол бүхий багш, судлаачид, суралцагч болон төгсөгчдөд инновацын төсөл бойжуулж, гарааны компани байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой хурдасгуур хөтөлбөр юм.

Хөтөлбөрт хамрагдах шаардлага: "MUST START-UP 3.0" хөтөлбөрт туршилт, судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон технологи, оюуны өмч, ноу-хау-д тулгуурлан зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нэвтрүүлэх зорилготой ШУТИС-ийн багш, судлаачид сонирхогч талууд (суралцагч, төгсөгч, гуравдагч этгээдтэй хамтарсан)-тай хамтарсан баг бүрдүүлэн хөтөлбөрт хамрагдах боломжтой ба хөтөлбөрт хамрагдах сонирхолтой баг дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Баг нь 3-аас дээш тооны гишүүнтэйгээр хүний нөөцөө бүрдүүлсэн байх;
- Багийн ахлагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны багш, судлаач байх;
- Багийн гишүүд нь бойжуулах хөтөлбөрт 20 долоо хоногийн хугацаа (сургалт, семинар, ментор зөвлөгөө)-нд бүрэн хамрагдах боломжтой байх;
- Зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төслийн санааг тухайн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн байх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загвар (prototype)-ыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийсэн байх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь оюуны өмчийн эрхийн хамгаалагдсан хийгдсэн байх эсвэл давтагдаагүй байдлыг нотлон тайлбарласан байх;

Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа: Хөтөлбөрт шалгарсан багуудтай гэрээ байгуулснаас хойш нийт 20 долоо хоногийн хугацаанд үргэлжилнэ.

Хөтөлбөрийн бүртгэл: 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдөр хүртэл бүртгэл явагдана.



Та бүртгүүлэхдээ дараах холбоосоор (линк) хандаж эсвэл QR уншуулан өөрийн gmail хаягийг ашиглан бүртгүүлэх юм.

Линк: <https://forms.gle/1ofWJ4cbXZAW5Qyq8>

Хөтөлбөрийн сонгон шалгаруулалт: Хөтөлбөрийн шалгаруулалт 2 үе шаттай зохион байгуулагдана.

Эхний шат: Хөтөлбөрт бүртгүүлсэн багуудын мэдээлэлд (бүтээгдэхүүн, үйлчилгээний технологийн боломж, зах зээл, бизнесийн үр ашиг, баг бүрдүүлэлт г.м) үндэслэн 2 дахь шатанд шалгаруулна.

Хоёрдугаар шат: Энэ шатанд шалгарсан багуудын дунд зах зээлд нэвтрүүлэхээр зорьж буй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах арга хэмжээ (pitch) зохион байгуулж “Гарааны компанийн төсөл бойжуулах **MUST START-UP 3.0**” хөтөлбөрт шалгарсан багуудтай гэрээ байгуулна.

Хөтөлбөрийн хүрээнд гарах давуу тал, боломж: Туршилт, судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон технологи, оюуны өмч, ноу-хау-г зах зээлд нэвтрүүлж, амжилттай гарааны бизнесийг үүсгэн байгуулахад “MUST START-UP 3.0” хөтөлбөр дараах ач холбогдолтой.

- Хөтөлбөрийн үр дүнд инновацын төслөө амжилттай хөгжүүлж төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрх бүхий албан ёсны гарааны компанийг үүсгэн байгуулах;
- Гарааны санхүүжилт авах боломж (seed fund);
- Бизнесийн мэргэшсэн зөвлөхүүдээс зах зээл, бизнесийн орчны талаарх ментор үйлчилгээ авах, энтрепренер ур чадварт суралцах боломж;
- Өөрийн технологийн хүрээнд салбарын эксперт, профессор мэргэжилтнүүдээс мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, баталгаажуулах (tech validation);
- Судалгааны лаборатори, нарийн мэргэжлийн багаж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглах;
- "MUST Sankou HUB" хамтын оффисын үйлчилгээ;
- ШУТИС-ийн орчин, дэд бүтэц, нөөцийг ашиглах (төслийн багт шаардлагатай оффис өрөө, уулзалт, хурал семинар зохион байгуулах заал, дадлага, туршилтын талбайгаар хангагдах гэх мэт);
- Харилцаа холбоо тэлэх (networking): Хөрөнгө оруулалт, технологи инновацын арга хэмжээ, олон улсын болон дотоодын үзэсгэлэн яармагт оролцож Старт-Ап экосистемд нэгдэх;

Хөтөлбөрийн талаар мэдээлэл, зөвлөгөө авах: Хөтөлбөрийн бүртгэл болон бусад асуудлаар мэдээлэл зөвлөгөө авах бол доорх хаягаар хандана уу.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч: ШУТИС-ийн Инновац, бизнес түншлэлийн алба

Хаяг: ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын төв байр (VIII)-ны 603 тоот өрөө

И-мэйл: itto@must.edu.mn

ШУТИС-ИЙН ИННОВАЦ, БИЗНЕС ТҮНШЛЭЛИЙН АЛБА